



6. Барилга, инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа

5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ



ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ МАГАДЛАН ШИНЖЛЭХ ШАЛГУУР

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 13 сарын 16 өдөр

Дугаар 1179

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг
магадлан шинжлэх шалгуур батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 22 дугаар зүйлийн 22.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өрхийн эрүүл мэндийн төвийг магадлан шинжлэх шалгуурыг нэгдүгээр, Сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан шинжлэх шалгуурыг хоёрдугаар, Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд магадлан шинжлэх шалгуураар үнэлгээ хийх аргачлалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн байгууллага, магадлан итгэмжлэлийн шинжээчдийг магадлан шинжлэх шалгуураар үнэлгээ хийх арга зүйгээр ханган, сургалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн байгууллага, шинжээчдэд хийх сургалтын зардлыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 07 дугаар тушаалын 3, 4, 5 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Бүртгэлийн дугаар 46

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 07 дугаар тушаалын 3, 4, 5 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

ХҮҮЛБАР ҮНЭН

Б.Зр

20 03 20

Д.САРАНГЭРЭЛ

Бүлгийн нэр	Дэд бүлгийн нэр
Бүлэг 1. Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд	1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал 2. Эмнэлгийн тусламжийн тасралтгүй байдал 3. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчид өгөх мэдээлэл 4. Үзлэг, оношилгоо, эмчилгээ 5. Халдварын сэргийлэлт, хяналт
Бүлэг 2. Байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шалгуурууд	1. Засаглал, удирдлага, манлайлал 2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлага 3. Хүний нөөцийн хөгжил 4. Мэдээллийн удирдлага, аюулгүй байдал. 5. Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ 2.6. Барилга, инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа
Бүлэг 3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд	I. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ II. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ 1. Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ 2. Хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ 3. Мэс заслын тусламж, үйлчилгээ 4. Мэдээгүйжүүлгийн тусламж, үйлчилгээ 5. Зорилтот бүлгийн үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээ 6. Халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээ

2.бүлэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгуур үзүүлэлт

Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ				
14.	Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журмыг мөрдөж ажиллана.	Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийдэг байх	1. Тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг хийлгэх гэрээтэй ажилладаг 2. Гэрээнд тоног төхөөрөмжийн урьдчилсан үзлэг, техникийн үзлэг, засвар үйлчилгээний хуваарь, зардлыг тусгасан 3. Гэрээний биелэлтийг дүгнэдэг 4. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт жил бүр захиалга өгч, багаж тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж ажилладаг	5, 4, 3, 2, 0
15.	Тоног төхөөрөмжийн стандарт, удирдамж, зааврын дагуу чанар, аюулгүй ажиллагааг хангасан байна	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, заавартай, санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавьдаг байх	1. Оношилгоо, эмчилгээнд ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг боловсруулж, баталгаажуулсан 2. Аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг ажлын байранд байршуулсан 3. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилтан бүрт өгдөг, гарын үсэг зуруулж баталгаажуулсан 4. Ашиглалт, аюулгүй ажиллагаанд тогтмол хяналт тавьдаг, хяналтын хуудас ашигладаг	5, 4, 3, 2, 0
16.		Эмнэлгийн тоног төхөөрөмжинд шалгалт тохируулга хийлгэдэг байх	1. Шалгалт тохируулгад шаардлагатай зардлыг байгууллагын төсөвт суулгадаг 2. Шаардлагатай тоног төхөөрөмжийг баталгаажуулах гэрээг мэргэжлийн байгууллагатай хийсэн 3. Лабораторийн хэмжих хэрэгслүүд, цусны даралтын аппарат, даралтын монометр, термометр, жин зэрэг хэмжих хэрэгслүүдийг баталгаажуулсан	5, 4, 3, 2, 0

14. Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийдэг байх



2018 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/344

Улаанбаатар хот

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого"-ын 2.4.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам"-ыг нэгдүгээр, "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх гэрээний үлгэрчилсэн загвар"-ыг хоёрдугаар, "Эмнэлгийн шинэ тоног төхөөрөмж хүлээн авах акт"-ыг гуравдугаар, "Засвар үйлчилгээний дараа хүлээлцэх акт"-ыг дөрөвдүгээр, "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалтын мэдээлэл"-ийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Д.Оюунчимэг/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2005 оны 298 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 08 сарын 28 өдрийн
А/344 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

"ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХЭВИЙН АЖИЛЛАГААГ ХАНГАХ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ" ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар №.....

201.. оны ... дугаар сарын ...

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 343-356 дугаар зүйл болон Эрүүл мэндийн сайдын 201.. оны ... дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам"-ыг баримтлан нэг талаас (цаашид "Захиалагч" гэх)-ийг төлөөлж ажилтай (цаашид "Гүйцэтгэгч" гэх)-ийг төлөөлж ажилтай нар дараах нөхцөлийг харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулав.

1.2 Гэрээ нь захиалагчийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх гэрээний хугацаа ... жил эсхүл ... сарын хугацаатай байна.

2.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийж гүйцэтгэхэд шаардлагатай зардлыг бүрэн хариуцаж холбогдох мэдээллээр гүйцэтгэгчийг хангана.

2.3 Гүйцэтгэгчийг засвар үйлчилгээ хийх орчин нөхцөлөөр хангана.

2.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн техникийн баримт бичгийн дагуу боловсруулсан ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлнэ.

2.5 Эмнэлгийн тоног төхөөрөмж дээр аллаа заасан засвар гэмтэл гарвал

СХД ЭМН болон 1-р амбулатори дахь аппаратуудын эргэлт, үйлчилгээний хуваарь

2017 он	Өдөрүүд																															
Сарууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	
1 сар																																
2 сар																																
3 сар																																
4 сар																©																
5 сар																																
6 сар																																
7 сар																																
8 сар																																
9 сар																																
10 сар																																
11 сар	*						©																									
12 сар																																

* Pentra ES60 аппараты эргэлт үйлчилгээний хуваарь

*** 2 жил, 1 жил, 6 сарын 3 төрлийн үйлчилгээний солих эд ангийг сольж бүрэн үйлчилгээ хийх

* 6 сарын үйлчилгээний эд ангийг сольж, цэвэрлэгээ үйлчилгээ хийх

© Cobas c111 аппараты эргэлт үйлчилгээний хуваарь

© Upgrade хийж аппараты CPU-г солих / Боловруулалтын хэсгийг солих. Энэ нь жил бүр хийгдэх үйлчилгээ биш юм.

© 1 жилд солигддог эд ангиудыг солих

ТЕХНИК АШИГЛАЛТЫН ПАСПОРТ № _____

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ № _____

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НЭР _____

15. Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, заавартай, санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавьдаг байх

БАТЛАВ:
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА С.ОЮУНЦЭЦЭГ

Кварц

- Зөөврийн кварцын аппарат нь физик эмчилгээ, эмчилгээний өрөө, хагалгааны өрөөнүүд гэх мэт тасгуудад ариутгал хийх зориулалтаар хэрэглэдэг.
- 1. Нийт ажиллуулах хугацаа нь 2 цаг
- 2. 20-30 минут унтраасны дараа дахин ажиллуулна.
- Ажиллах зарчим
- Аппаратаа ариутгах орчиндоо байрлуулна.
- Аппаратаа цахилгаан тэжээлд залгана.
- Нүүрэн талд байгаа "Пуск" кнопыг дарж асаана.
- Аппаратыг 2 цагаас илүү ажиллуулж болохгүй
- Аюулгүй ажиллагааны зарчим
- Цахилгааны утас шалбарсан, вилк гэмтсэн үед залгахыг хориглоно.
- Гэрлийг асаалттай үед гар хүрч болохгүй.
- Гэрэл асахгүй гэмтсэн тохиолдолд хариуцсан инженер техникчидийг дуудна.
- 2 цагаас дээш тасралтгүй ажиллуулахыг хориглоно.
- Гэрэл асч буй үед хамгаалалтын хамгаалалтын шилгүй өрөөнд орохыг хориглоно.

АНХААРУУЛГА: Аюулгүйн ажиллагааны заавар дүрмийг мөрдөхгүйгээр аппарат тоног төхөөрөмжийг ажиллуулж гэмтээсэн тохиолдолд аппарат тоног төхөөрөмж хариуцан ажиллаж байгаа ажилтан хариуцлага хүлээнэ.

Заавар боловсруулсан: Эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээлэл технологийн алба
ЭТТ-ийн инженер / Д.Баярхүү /



Эмнэлгийн тоног төхөөрөмжинд шалгалт тохируулга хийлгэдэг байх



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалт, Засгийн газрын "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 1995 оны 101 дүгээр тогтоолын 5 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам"-ыг нэгдүгээр, "Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх төлбөрийн хэмжээг тооцох аргачлал"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т тус тус даалгасугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

245	15.002	Дефибриллятор	60000
246	15.003	Дуслын автомат шахуурга	56000
247	15.004	Тариурын автомат шахуурга	61000
248	15.005	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	55000
249	15.006	Наркозын аппарат	100000
250	15.007	Нярайн дулаацуулах ширээ	51000
251	15.008	Нярайн инкубатор	84000
252	15.009	Өвчтөний хяналтын төхөөрөмж, мониторинг	51000
253	15.010	Рентген аппарат /компьютер томографийн аппарат/	90000
254	15.011	Хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч	30000
255	15.012	Хэт авиан оношлогооны аппарат	15000
256	15.013	Цахилгааны аюулгүй байдал	19000
257	15.014	Мэс заслын цахилгаан аппарат	55000


2.бүлэг барилга, инженерийн байгууламжийн аюулгүй

Барилга, инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа				
17.	Төвийн усан хангамж болон цахилгааны нөөцийг бүрдүүлж, хэвийн ажиллагааг хангана.	Байгууллагын хүчин чадалд тохирсон цахилгааны нөөц үүсгэвэртэй байх	1. Цахилгааны нөөц үүсгэвэртэй, ажиллагааг тогтмол хянадаг 2. Цахилгааны нөөц үүсгэвэр нь байгууллагын хэмжээнд тусламж, үйлчилгээг хэвийн явуулах хүчин чадалтай 3. Сэлгэн залгалтын хэвийн ажиллагааг сар тутамд зохих мэргэжлийн байгууллагатай хамтарч хянадаг, баримтжуулсан	5, 4, 3, 2, 0
18.		Байгууллагын усан хангамжийн үйлчилгээ тасралтгүй байх	1. 24 цагийн усан хангамжтай 2. Усны тасалдал гарсан тохиолдолд зохицуулах арга хэмжээг төлөвлөсөн 3. Ундны усны шинжилгээтэй, шаардлага хангасан	5, 4, 3, 2, 0
19.	Галын аюулгүй байдлыг хангаж ажиллана	Галын аюулгүйбайдал, гал унтраах техник, хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтад хамруулсан байх	1. Байгууллагын хэмжээнд мөрддөг галын аюулгүй ажиллагааны батлагдсан заавартай, мөрддөг 2. Харьяалах нутаг дэвсгэрийн Онцгой байдлын газар/ хэлтэстэй хамтран ажилтнуудад жилд 1-2 удаа галын аюулгүй байдлын дадлага, сургалтыг зохион байгуулж, баримтжуулсан 3. Галын аюулаас урьдчилан сэргийлэх буланг шаардлагатай цэгүүдэд байршуулсан 4. Гал унтраах хэрэгслийг ашиглах зааврыг өгдөг 5. Аврах гарцын схем, тэмдэг тэмдэглэгээнүүдийг шаардлагатай цэгүүдэд байршуулсан 6. Харьяа аймаг, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтсээс жил бүр дүгнэлт гаргуулсан	5, 4, 3, 2, 0

17. Байгууллагын хүчин чадалд тохирсон цахилгааны нөөц үүсгэвэртэй байх



18. Байгууллагын усан хангамжийн үйлчилгээ тасралтгүй байх



ЦАЛТАНСҮХ-Д

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА
213100 Баруун-Урт, Сүхбаатар аймгаар
Утас: факс 7851-8941
P. su@inspection.gov.mn
www.inspection.gov.mn

АМС-01-10 № 17-03-015/01

Зөрчил арилгуулах тухай

Баруун-Урт сумын иргэдээс ирүүлсэн удаа дараагийн гомдол, хүсэлтийн дагуу "Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт" MNSO900:2005 стандартын норм, нормативын хэрэгжилтэнд Эрүүл ахуй халдаар хамгааллын хяналтын улсын байцаагч Э.Мөнхнаран "Дөрвөлж" ОНӨҮГазрын холбогдох албан тушаалтнуудыг байлцуулан 2015 оны 01 сарын 08 өдөр шинжилгээтэй хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

Хяналт шалгалтын үеэр "Дөрвөлж" ОНӨҮГазрын цэвэрлэх биолууламж болон 4, 9-р ус түгээх цэгүүдээс дээж авч, Газрын нэгдсэн лабораторид шинжлүүлэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Лабораторийн 01-03 тоот дүнгээс үзэхэд ундны усны үлдэгдэл хлорын хэмжээ нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 0.1 хувиар их байгаа нь "Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт" MNSO900:2005 стандартыг зөрчсөн байна.

Иймд дээрх илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Монгол Улсын "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 10-р зүйлийн 10.9.8-д заасан бүрэн эрхийн дагуу ШААРДАХ нь:

1. Ундны усны үлдэгдэл хлорын хэмжээг стандартад заагдсан ЗДХ-нд байлгах арга хэмжээг шуурхай авч ажиллах шаардлагатай.

Энэхүү албан шаардлагыг 2015 оны 01 сарын 14-ны дотор бичгээр ирүүлэхийг мэдэгдье.

Албан шаардлагыг биелүүлээгүй, хугацаанд нь хариу ирүүлээгүй тохиолдолд "Төрийн хяналт шалгалтын тухай хууль"-ийн 16.1.2 дахь заалтын дагуу

19. Галын аюулгүйбайдал, гал унтраах техник, хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтад хамруулсан байх

